

Баян-Олгий аймгийн залуучуудын байгууллага чуулган зохион байгуулах зар тараав. «Ажилтай, орлоготой залуучууд» сэдэвтэй уг чуулга уулзалт энэ сарын 29-30-нд болж, эхлээд онолын бага хурал, дараа нь хэлэлцүүлэг, сургалт зохионо.

Чуулганд ходоо сум бүрээс тав, Олгий сумын баг тус бүрээс гурван толоологч урилгаар оролцох бөгөөд сонирхсон бусад хүмүүс чолоотэй оролцож болох юм байна. "Бага хурлаар илтгэл уралдуулахаар болзол гаргалаа. Тэргүүн байр сая тогрогийн шагналтай. Тус нутагт нэн тулгамдсан ажилгүйдлийн асуудлыг шийдвэрлэх нь бидний гол зорилт юм. Иймд шинжлэх ухааны үндэстэй, амьдралд нийцсэн, ажлын байр олноор бий болгох үр огоожтэй, оновчтой санал дэвшүүлсэн илгэлийг шалгаруулна. Хамтран ажиллаж үр дүнд хүрэх арга замыг сүвэгчилсэн сургалт хийнэ. Бидний энэ санаачлагыг аймгийн ЗДТГ дэмжиж байгаа бөгөөд аймгийн удирдлага, Монгол Улсын Ерөнхийлогчийн хэвлэлийн толоологч С.Эрдэнэболд уг чуулганд оролцохоор боллоо гэж аймгийн залуучуудын холбооны тэргүүн Ж.Харшыга мэдээллээ.